

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/01

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар
зүйлийн 7.6 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
Тооллогын комиссын 2 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ**
нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 2026/10 тогтоолоор
гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/02

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын омпанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт болон 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 3 тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрмийн 1.4 дэх заалтыг "Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь **Ard** Кредит ББСБ байх ба АРД гэсэн үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна." гэж өөрчилсүгэй..
2. Энэхүү шийдвэрийн 1 дэх хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/03

Улаанбаатар хот

Компанийн тамгыг шинэчлэн
солиулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь хэсэг, , 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 4 тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн брэнд төрх шинэчлэгдэж, компанийн лого өөрчлөгдсөнтэй холбогдуулан одоо ашиглагдаж буй тамгыг хураалгаж, тамганы хяналтын дугаар шинээр авахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангуулж холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатарт)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

2026 оны 4 сарын 27-ны өдөр

№2026/04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026
оны төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 5 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсвийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын 2026/04 тоот тогтоолын хавсралт



Төлөөлөн Удирдах Зөвлөл	Гишүүдийн тоо	Сар	Нэг сарын цалин	2026 төсвийн санал /төгрөг/
Үндсэн цалин				123,780,000
ТУЗ дарга	1	12	1,495,000.00	17,940,000
Хорооны дарга	4	12	1,150,000.00	55,200,000
ТУЗ-ийн гишүүн	4	12	805,000.00	38,640,000
ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга	1	12	1,000,000.00	12,000,000
Урамшуулал				55,890,000,
Сургалт, хурлын зардал				13,500,000
Нийт				193,170,000

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.2 дахь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 6 тоот тогтоолыг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах нэр дэвшигчдийг сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүд:
 - 1.1.1. Хүрэлбаатарын Билгүүн;
 - 1.1.2. Чулууны Ганзориг;
 - 1.1.3. Мөнхбатын Мөнх-Эрдэнэ;
 - 1.1.4. Одончимэдийн Одбаяр;
 - 1.1.5. Галнямын Уянга;
 - 1.1.6. Гүррагчаагийн Сүхбаатар;
 - 1.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүд:
 - 1.2.1. Ванчигийн Ганзориг;
 - 1.2.2. Батсүрэнгийн Солонго;
 - 1.2.3. Сүхбаатарын Энхчимэг;
2. Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 3 (гурав) жилийн хугацаатай бөгөөд ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болохыг дурдсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлж, зохих зөвшөөрлийг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Есү-Үжин)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ